



"АРИГ ГАЛ"
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 02.26

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Ариг гал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 29-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 19-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг сонсох;

2.2 Компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

2.3 Компанийн 2025 оны санхүүгийн тайлан балансад аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтийг танилцуулах

2.4. 2024 оны үр дүнгээр зарласан ногдол ашиг тараасан тухай тайланг танилцуулах

2.5. Компанийн 2025 оны үйл ажиллагааны ашгаас хувьцаа эзэмшигчдэд НА тараахаар ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулах

2.6 ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

2.7 2025 оны үйл ажиллагааны ашгаас ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллыг хэлэлцэж батлах

2.8 2026 оны компанийн удирдлагын үйл ажиллагааны зардлын төсөвийг хэлэлцэж батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Ариг гал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Даргын Ажлын Албаны дарга С.Оргодолыг, тооллогын комиссын даргаар П.Цэрэнсчирыг томилсугай.

4. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон МХБ-д мэдэгдэх өдрийг 2026 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр зарлах өдрийг 2026 оны 3 дугаар сарын 23 болон 4 дүгээр сарын 07-ны өдрүүдээр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.

6. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын танилцуулгыг компанийн цахим хаягт байршуулан нийтэд хүргэх, брокерий компаниудаар тараах материалыг 2026 оны 3 сарын 28 дотор хүргүүлэх, эхний болон давтан зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэн, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисс (С.Оргодол)-д даалгасугай.

7. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер диллерийн компаниуд дээр бэлэн байлгах, Имайлаар хүргүүлэн, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулахыг, Хурал зохион байгуулах комисс (С.Оргодол)-д үүрэг болгосугай.

М

Үүнд:

- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
- 7.2. 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайлан
- 7.3. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гаргах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, компанийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт;
- 7.4. Хурлын санал хураах хуудасны загвар.
- 7.5. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга, Нэр дэвшүүлэх хорооны тогтоол
- 7.6. Компанийн удирдлагын зардлын 2026 оны зардлын төсөв
- 7.7. Хувьцаа эзэмшигчдэд 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлын 01/26 тоот тогтоол
- 7.8. 2026 оны үйл ажиллагааны ашгаас ТУЗ-ийн гишүүдэд олгох урамшууллыг төсөл
- 7.9. Хурлаас гаргах шийдвэрээр гаргах тогтоолын төслүүд
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
9. Санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2026 оны 04 дугаар сарын 29-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг, хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /С.Оргодол/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

Б.БОЛД

Б.АЮУШ

Э.БЯМБАЖАВ

З.СҮХБААТАР

С.АЛИМАА

Х.МӨНХТУЯА

Handwritten signature